

УРИЛГА

2025.09.19

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын арбитра хянан хэлэлцэгдэж буй хэрэг маргаанд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн эрх ашгийг хамгаалан, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар хууль зүйн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх өмгөөлөгчтэй хамтран ажиллах нээлттэй урилгыг хүргүүлж байна.

1. Сонгон шалгаруулалт

- 1.1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаас 5 (тав)-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалт явуулах тухай зарлалыг компанийн албан ёсны www.dmp.mn цахим хуудсаар зарлан мэдээлнэ.
- 1.2. Сонгон шалгаруулалтад оролцох өмгөөлөгч /цаашид “оролцогч” гэх/-ийг бүртгэх ажиллагаа нь сонгон шалгаруулалтын товыг зарласан өдрөөс эхэлж, сонгон шалгаруулалт эхлэхээс 2 (хоёр) хоногийн өмнө дууссан байна.
- 1.3. Сонгон шалгаруулалтад оролцогч нь Өмгөөллийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтад тэнцэж, өмгөөллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, өмгөөллийн үйл ажиллагааны эрх авсан байна.
- 1.4. Сонгон шалгаруулалтад оролцогч нь өөрийн боловсрол, ажил мэргэжлийн болон туршлагын танилцуулгыг холбоо барих утасны дугаар, ажлын хаягийн хамт /PDF хэлбэрээр/ бүрдүүлж, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн албан ёсны info@dmp.mn цахим шуудангаар эсхүл биет хэлбэрээр ирүүлж болно.
- 1.5. Бүртгэл явуулах хугацаанд багтаан мэдээллийг бүрэн ирүүлээгүй, тавигдах шаардлагыг хангаагүй болон шаардлага хангахгүй баримт ирүүлсэн бүрдүүлсэн оролцогчийг бүртгэхгүй.
- 1.6. Шаардлагатай тохиолдолд оролцогчийн бүрдүүлсэн баримт бичгийн үнэн зөв эсэхийг шалгах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтнаас тодруулна.

2. Ерөнхий шаардлага

- 2.1. Эрх зүйн дээд боловсролтой (Дээд боловсролын диплом, гадаадад төгссөн бол баталгаат орчуулга);
- 2.2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч байх;
- 2.3. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээтэй байх;

3. Тусгай шаардлага

- 3.1 Өмгөөлөгчөөр 20 жилээс доошгүй хугацаанд ажилласан туршлагатай байх;
- 3.2 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн байх; (Санхүүгийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн бол давуу тал болох);
- 3.3 Гэрээний маргаан, санхүү, эдийн засгийн чиглэлээр эрүү, иргэн, арбитрын хэрэг маргаанд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;
- 3.4 Хэрэг маргааны бусад оролцогчтой ашиг сонирхлын зөрчилгүй байх;
- 3.5 НӨАТ-ын баримт шивэх, татварын тайлан гаргадаг татвар төлөгч байх;

4. Гэрээ байгуулах.

4.1 Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчидтой холбогдон уулзалт зохион байгуулж, хэргийн үйл баримтын талаарх мэдээллийг өгч, Арбитрын маргаанд зөвлөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх төлбөрийг харилцан тохиролцож, шийдвэрлэсний үндсэн дээр “Хууль зүйн туслалцаа үзүүлэх” гэрээг байгуулж хамтран ажиллана.

**Санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2025 оны 09 дүгээр сарын 25-ний өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

**Санал хүлээж авахтай холбоотой тодруулгыг
доорх цахим хаягт эсхүл компанийн ажлын байранд ирүүлнэ үү
info@dmp.mn**